

АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Хугацаа: Хуанлийн 103 хоног, ажлын 71 өдөр

Эхлэх хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Дуусах
хугацаа: 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

Зорилго	“Шударга байдлын үнэлгээ”-ний аргачлал, судалгааг зохион байгуулах удирдамж, асуулгын маягтыг шинэчлэн, түүнийг ашиглах зөвлөмж бүхий судалгааны тайлан боловсруулахад оршино.
Үндэслэл	“Шударга байдлын үнэлгээ”-ний аргачлал, судалгааг зохион байгуулах удирдамж, асуулгын маягтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 59 дугаар тушаалаар баталж 2010, 2012, 2014 онуудад төрийн шударга байдлын үнэлгээний ажлыг гүйцэтгэж үр дүнг мэдээлсэн байна. Мөн АТГ-ын даргын 2015 оны А/129 дугаар тушаалаар уг аргачлалыг шинэчлэн боловсруулж 2015-2024 онд 7 удаагийн судалгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцоолжээ. Гэвч уг аргачлалыг шинэчлэн баталсан хугацаанаас хойш Монгол Улс дахь авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчин болон төрийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаанд нэлээдгүй өөрчлөлт гарч, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй арга, аргачлалд өөрчлөлт, шинэчлэлтийг тусгах, олон улсын сайн туршлага, шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.
Зөвлөхийн гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хангаж ажиллана. Үүнд: • “Шударга байдлын үнэлгээ”-ний арга зүйд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргах; • “Шударга байдлын үнэлгээ”-ний асуулгад дүн шинжилгээ хийж, үр дүнг тодорхойлох; • Зорилго, зорилтын хүрээнд хийгдэж буй ажлын үр дагаврыг тооцоолсон байх; • Техник технологи, инновацыг нэвтрүүлж аргачлалыг шинэчлэн боловсруулах; • Гадаад улсуудын ижил төстэй судалгаа, үнэлгээний арга зүй, асуулгатай харьцуулан дүгнэлт гаргах; • “Шударга байдлын үнэлгээ”-ний тайлан, үр дүнд хугацааны цуваа, статистик шинжилгээ хийж үр дүнг тогтоох; • “Шударга байдлын үнэлгээ”-ний аргачлал, судалгааг зохион байгуулах удирдамж, асуулгын маягтыг шинэчлэх санал, зөвлөмж бүхий тайлан боловсруулах;
Зөвлөхөд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: Зөвлөхийн баг нь дараах мэргэжил, туршлага бүхий 2-3 гишүүнтэй байна. • Төрийн удирдлага, социологи болон бусад холбогдох нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн мэргэжилтэй байх; • Монгол Улсын засаглалын тогтолцоо, хууль, эрх зүйн орчны талаар маш сайн мэдлэгтэй байх; • Англи хэлний бичгийн болон ярианы ур чадвар эзэмшсэн байх; • Судалгаа шинжилгээ, үнэлгээний ажлын арга, аргачлал боловсруулахад оролцож, үр дүн гаргасан байх (давуу тал болно);

	Бусад • Судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, өмнө нь хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай зөвлөх байх;
Тайлангийн хуваарь	• Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явцыг цахимаар тайлагнаж байна;
Судалгааны тайланд тавигдах техник шаардлага	• Судалгааны ажил нь агуулгын хувьд харилцан уялдаатай, иж бүрэн, шинжлэх ухааны тодорхой арга зүйг үндэслэсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн, онол-практикийн ач холбогдол бүхий байна; • Судалгааны үр дүнг хэлэлцүүлгээр танилцуулах ажлыг зохион байгуулна;
Ирүүлэх санал	Шалгаруулалтыг сонгох аргаар явуулна. Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ: • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт /албан бичгээр/; • Ажлын даалгаврын гүйцэтгэх бүрэлдэхүүний мэдээлэл; • Боловсрол, ур чадварын талаарх мэдээлэл; • Ажлын туршлагын хураангуй болон уг даалгаврыг гүйцэтгэх чадвартай болохыг нотолсон баримт бичиг; • Сүүлийн 5 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаарх танилцуулга /хамгийн багадаа 2 ажил/; • Даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон үнийн санал, зардлын тооцоо;

---oOo---